



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Оффисын ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Гагнуурчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.
3. Зааварчилгааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, аудитын алба /Л.Батбаяр/-д даалгасугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М.ГАНБААТАР

	Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04	БАТЛАА ГҮЙЦЭТГЭХ АЖИРАЛ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он / М 19 / сар / 19 / өдөр
		Тушаал № А/162	

ӨРГӨХ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

ӨРГӨХ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага	4
Хоёр. Ажил эхлэхийн өмнөх аюулгүйн шаардлага	4
Гурав. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	5
Дөрөв. Ажил дууссаны дараах аюулгүйн шаардлага	7

Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04
	Хувилбар: 1

НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 1.1. Канаттай (тросс) өргөгч механизм болон гар тайл эсвэл ороогч зэрэг ачаа татагч төхөөрөмж ашиглах ажилтан нь тусгай хөтөлбөрөөр суралцаж, ХАБЭА-н ажилтан болон ИТА-аас ачаа өргөх механизм болон тоног төхөөрөмж ашиглах эрх авсан байна.
- 1.2. Гар тайл, гар ороогчийг удирдах, эдгээрт ачааг тогтоох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг шууд удирдлагаас (ээлжийн ахлах, ажил удирдагч) 12 сард нэгээс доошгүй удаа авсан байна.
- 1.3. Өргөгч төхөөрөмжтэй ажиллах ажилтан дараах зүйлсийг мэддэг, эзэмшсэн байх шаардлагатай:
 - Ачаа өргөх төхөөрөмжийн зориулалт, хүчин чадал, техникийн тодорхойлолт;
 - Техник үйлчилгээ, засвар, үзлэгийн хуваарь, өмнөх техник үйлчилгээ, засвар, үзлэгийн үр дүн;
 - Ачааг оосорлох, өлгөх аюулгүй арга барил;
 - Ачааг зөөх хураах дараалал;
 - Канат, гинж, хөдөлгөөнт тохируулагч болон баглаа боодолд тавигдах шаардлага, тэдгээрийн элэгдлийн норм;
 - Өргөх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцсан инженер-техникийн ажилтан (ашиглалтын инженер, ээлжийн ахлах), засварчинтай яаралтай холбогдох арга;
 - Гал унтраах багаж зэвсэглэлийн байршил, түүнийг ашиглах арга аргачлал;
- 1.4. Үйлдвэрийн байранд ачааг оосорлох, өлгөх аргачлал, зөөх ачааны зөвшөөрөгдөх жин, ачааг хураах схемийг хананд байрлуулсан байна.
- 1.5. Өргөх төхөөрөмжийг техникийн паспортад тусгагдсан хуваарийн дагуу техникийн засвар, үйлчилгээ, үзлэгийг хийсэн байна.
- 1.6. Өргөх төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хариуцсан инженер-техникийн ажилтан, түүнийг ажиллуулдаг ажилтан хоёр бүрэн хариуцна.

ХОЁР. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 2.1. Ажлын тусгай хувцас, гутал өмсөж, ажлын байрны нөхцөл, хийх ажлын онцлогт тохирсон хувийн хамгаалах хэрэгслийг бэлдсэн байна.
- 2.2. Ачаа өргөх төхөөрөмжтэй ажиллах ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажлын талбайд гаргана.
- 2.3. Ажлын байранд дараах зүйлсэд үзлэг хийнэ:

Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04
	Хувилбар: 1

- Өргөх ачааны жин өргөх механизм, түүний канат трос зэргийг даацад тохирч байгаа эсэхийг шалгах.
 - Өргөх ачааны баглаа боодол бүрэн бүтэн эсэх, түүн дээрх дугаар, зориулалт, жин бүхий бичиг байгаа эсэх;
 - Дамжуулагч, холхивч, канатын тослогоо, сальник, тослогооны төхөөрөмжийн байдал;
 - Төхөөрөмжийн метал эд ангийн гагнасан, боосон зэрэг бэхэлсэн хэсгүүд;
 - Канат, гинж, тэдгээрийн дамарт бэхлэгдсэн байдал;
 - Дэгээ, түүний бэхэлгээ, ээлжийн ачаа базагч;
- 2.4. Үзлэгийн дараа ачаа өргөх аюултай орчинд хүн байхгүй байгаа эсэхийг нягталж, тус бүсэд шаардлагагүй хүмүүсийг нэвтрүүлэхгүй байх боломжийг бүрдүүлнэ.
- 2.5. Ажлыг гүйцэтгэхээс өмнө төхөөрөмжийг асааж буюу хоосон явуулж хэвийн ажиллагааг шалгана.
- 2.6. Үзлэг болон шалгалтаар ямар нэг доголдол илэрвэл, түүнийг засах арга хэмжээ авна. Хэрэв өөрөө хийх боломжгүй бол ажлаа эхлүүлэхгүйгээр шууд удирдлагад мэдэгдэнэ.
- 2.7. Ажил эхлүүлэхгүй байх тохиолдлууд:
- Гадна их биед цууралт, гажилт үүссэн, эрэг боолт эсвэл бэхэлгээ суларсан;
 - Канатын бэхэлгээний хавчигч гэмтсэн эсвэл байхгүй болсон, боолт суларсан;
 - Ачилтын канат эмтэрсэн, элэгдэл нормыг давсан, түгжээ нь мултарсан болон дэгээний нугалаа гэмтэлтэй;
 - Ачаа өргөх төхөөрөмж болон түүний эд анги эвдрэл гэмтэлтэй ;
 - Канатын блок гэмтсэн;
 - Дэгээ болон блок эргэлдэхгүй болсон;
 - Өргөх төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх үзлэгийн эсвэл ашиглалтын болон техникийн үйлчилгээний хугацаа дууссан;
- 2.8. Ажлын байрны гэрэлтүүлэг хангалтгүй;

ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- 3.1. Өргөх төхөөрөмжтэй ажиллахдаа төхөөрөмжийг ашиглах заавар, ажлын төлөвлөгөө, технологийн картыг мөрдөж ажиллана.
- 3.2. Ажлын цагаар төхөөрөмж ажиллуулж байхдаа түүнийг цэвэрлэх, тослох, засварлахыг хориглоно.

Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04
	Хувилбар: 1

- 3.3. Ажлын байранд зөвшөөрөлгүй хүн оруулах, төхөөрөмжийн удирдлагыг шууд удирдлагын шийдвэргүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 3.4. Ачаа өргөхөд заавал ханцуйвч хэрэглэнэ.
- 3.5. Өргөх төхөөрөмжтэй ажиллахдаа дараах зарчмыг баримтална:
- Хэн өгснөөс үл хамааран “Зогс” дохиог биелүүлнэ;
 - Өргөх төхөөрөмжийн бүсэд хүн байхгүй үед ачааг өргөнө;
 - Өргөсөн ачааны доогуур болон барилга байгууламжийн хана, машин механизм, тоног төхөөрөмж зэрэг хатуу биет ачаа хоёрын хооронд хүн зорчихгүй, орж зогсохгүй байхаар ажлыг төлөвлөнө.
 - Ган татлага налуу байрлалд орохоос сэргийлж, дэгээг ачааны дээр байрлуулна;
 - Ачааг 20-30 сантиметрийн өндөрт өргөж, оосорлолт зөв, бэхэлгээ найдвартай эсэхийг нягталсны дараа шаардлагатай өндөрт өргөнө;
 - Ачааг хэвтээ чиглэлд шилжүүлэн зөөх замд тохиолдож болох зүйлээс 50 сантиметрийн өндөрт өргөсөн байна;
 - Цөөн ширхэгтэй, нунтаг, шингэн, хүндийн төвийг тодорхойлох боломжгүй ачааг сав боодолд хийж өргөнө;
 - Ажиллаагүй байгаа өргөгч төхөөрөмжийн дэгээг ямагт дээд байрлалд өргөсөн байна;
 - Ачааг оосорлохдоо батлагдсан оосорлолтын схемийн дагуу хийнэ. Оосорлолтын схемийг боловсруулаагүй ачааг зөөхдөө аюулгүй ажиллагааг хариуцсан удирдах ажилтныг байлцуулна;
 - Ачааг технологийн картын дагуу унах, асгарах, гулгах эрсдэлийг арилгаж, тогтоосон газар жигд буулгана;
 - Ачааг жигд аажим өргөнө;
 - Оосорлогчийн үнэмлэхгүй ажилтан ажиллуулахгүй;
 - Өргөх төхөөрөмжийн даацаас хэтэрсэн ачаа, жинг тодорхойлох боломжгүй, асгарсан, газарт бэхлэгдсэн ачааг өргөхийг хориглоно;
 - Ачааг огцом өргөхийг хориглоно;
 - Ачааг өргөсөн байдалд орхихыг хориглоно;
 - Газар шүргэсэн, бусад ачаатай холилдсон, боолтоор тээглүүлсэн, эд зүйлд орооцолдсон ачааг өргөж тасдах, урах үйлдэл хийхийг хориглоно;
 - Хүнтэй ачаа, хүн гараараа түшиж тэнцвэрийг олж байгаа ачааг өргөхийг хориглоно;

Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-04
	Хувилбар: 1

- Тусгай саванд хийгээгүй шахсан, шингэрүүлсэн хийн баллоныг өргөхийг хориглоно;
- 3.6. Дараах тохиолдолд ажлыг зогсоож шууд удирдлагад мэдэгдэнэ.
- Өргөх төхөөрөмжийн механизм, төмөр хийц эвдрэх;
 - Ажлын байрны гэрэлтүүлэг хангалтгүй;
 - Хүчтэй цасан болон шороон шуурга, аадар бороо, манан буусан;
 - Агаарын температур төхөөрөмжийн паспорт дээр заасан ажиллах зөвшөөрөгдөх хэмжээнээс бага болсон;
 - Барабан болон блокоос канатыг буруу хураасан, канат гэмтсэн;
 - Төхөөрөмжийг ажлын байранд найдваргүй бэхэлсэн;
 - Цахилгаан дамжуулагчийн хаалт хамгаалалт байхгүй;
- 3.7. Гар хөшүүрэгт удирдлагатай ороогчоор ажиллах үед дараах зүйлсийг хориглоно:
- Хөшүүргийн эргэх талбай болон өргөсөн ачааны доор хүн зогсох;
 - Техникийн тодорхойлолтод зааснаас урт хэмжээний хөшүүрэг хэрэглэх;
 - Хөшүүргийг нэг эцсийн байрлалаас нөгөө байрлалд нэвт эргүүлэх;
- 3.8. Ачаа өргөх төхөөрөмжийг засварын дараа зөвхөн инженер-техникийн ажилтны бичгэн зөвшөөрлөөр ажилд оруулна.

ДӨРӨВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 4.1. Ачааг дэгээ болон базах төхөөрөмжөөс салгана.
- 4.2. Төхөөрөмжийг тогтоосон зогсоолд тавьж, дэгээг дээш өргөн хамгийн дээд цэгт байрлуулна.
- 4.3. Ажлын явцад гарсан аливаа доголдлын талаар шууд удирдлагад мэдэгдэнэ.